



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Г ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР Г
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
А.ЗАНГАД ТАНАА

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,
Утас/Факс: (976-11) 32-06-68

2016.09.05 № 1/1941
танай _____ -ны № _____ -т

Г Мэдэгдэл хүргүүлэх тухай

Үндэсний Аудитын газраас Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг танай байгууллагын цахим хуудаснаас үзэж танилцлаа.

Энэхүү тайлангийн МУИС-тай холбоотой дүгнэлтүүдийн талаар дараах мэдэгдлийг Танд хүргүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А/74 дүгээр тушаалын хавсралтаар "Төлбөр, зөрчлийн жагсаалтын"-ыг гаргаж, энэхүү жагсаалтын 14 дүгээрт МУИС-ийн захирал Р.Бат-Эрдэнэд 5,635.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах талаар 6/145 тоот акт, албан шаардлагыг хүргүүлсэн гэжээ. Танай 5 дугаар сарын 19-ний өдрийн 4/894 тоотоор бидэнд ирүүлсэн тайлангийн эхний төслийг хүлээн авч танилцаад, 05 дугаар сарын 24-ний өдөр тайланд дурдагдсан ташаа дүгнэлтийн асуудлаар танай байгууллага дээр хамтран уулзаж, манай зүгээс зөвшөөрөхгүй байгаа асуудлуудад тайлбар өгсөн. Энэхүү тайлбарыг албан ёсоор бичгээр хүргүүлэх шаардлагын дагуу баримт нотолгоогүй ташаа дүгнэлт бүрт 42 хуудас тайлбар, 297 хуудас нэмэлт судалгаа, баримт нэг хавтас материалыг 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/1205 тоотоор танайд хүргүүлсэн. Бидний хүргүүлсэн тайлбартай танилцаад, ямар нэгэн хариу өгөөгүй, эцсийн дүгнэлтийг хариуцах талд танилцуулахгүйгээр албан ёсны цахим хуудсандаа байршуулсаныг тань хөндлөнгийн хэвлэлийн мэдээнээс үзлээ.

Энэхүү акт, албан шаардлага нь ямар үндэслэлтэй нь тодорхойгүй бөгөөд, Таны А/74 дүгээр хавсралтанд дурдсан акт, албан шаардлагыг өнөөдрийг хүртэл МУИС хүлээн аваагүй байна.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

20161495



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,
Утас/Факс (976-11) 32-06-68

2016.09.30 № 1/2270
танай 2016.08.13 -ны № 4/1193 -т

Г ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
А.ЗАНГАД ТАНАА

Г Мэдэгдэл хүргүүлэх тухай

Танайхаас 2016 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн 4/1193 тоотор 09 дүгээр сарын 23-ны өдөр манайд ирүүлсэн "Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын дэд тайлантай танилцлаа. Танай байгууллагаас энэхүү дэд тайлангийн эхний төслийг 2016 оны 5 дугаар сард ирүүлсэн даруй 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 4/894 тоотор, "Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан"-г танай цахим хуудсанд тавигдсаны дараа 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1941 тоотор бид бүхэн дэлгэрэнгүй тайлбар хүргүүлсээр атал манайхаас хүргүүлсэн тайлбарыг нягталж тусгалгүйгээр албан шаардлага ирүүлсэн байна.

Энэхүү албан шаардлага нь тус сургуулийн хэмжээнд сургалтын төлбөрийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан албан ёсны аргачлалд үндэслэн, хуульд нийцүүлэн тооцож байгааг харгалзаж үзээгүй байна. Түүнчлэн сургалтын төлбөрийн асуудлаар эцсийн шийдвэр гаргадаг хуулиар олгогдсон эрх бүхий цорын ганц субъект болох тус сургуулийн Удирдах зөвлөл боловсролын тухай хуулиудад оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу шинээр бүрдэх үйл явц дуусаагүй байгаа тул танай албан шаардлагыг хэрэгжүүлэх боломжгүй байгааг үүгээр мэдэгдье.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

20161555